

**“УЛААНБААТАР ХОТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ 3R (REDUCE, REUSE, RECYCLE) ДАДАЛ БУЮУ 3R4UB” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “ХАКАТОН 2022-3R CONTHACKT UB” УРАЛДААНД ХЭРЭГЛЭГДЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

**Төслийн нэр:** “Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төсөл

**Лавлах дугаар:** 5.8.21

**Хугацаа:** 2022 оны 11-р сарын 25 -2022 оны 11-р сарын 27

**Төсөв:** 1,112,150 төгрөг

**НЭГ. Ерөнхий зүйл**

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь SWITCH-Asia ба Төв Ази II буюу Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг дэмжих нь хөтөлбөрийн хүрээнд Европын холбооноос санхүүжүүлж буй “Улаанбаатар хотод 3R зарчмыг хэрэгжүүлэх замаар байгалийн нөөцийг тогтвортой ашиглах (3R4UB)” төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Итали Улсын Үндэсний судалгааны зөвлөл, Итали Улсын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэг “Металлиа сервиси” компани хамтран хэрэгжүүлж байна.

Монгол улсын хэмжээнд бүх нийтийг оролцуулсан тогтвортой хөгжлийг бий болгох, ядуурлыг бууруулах, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан нүүрстөрөгч бага ялгаруулдаг, байгалийн нөөцийг үр ашигтай ашигладаг эдийн засгийг дэмжих үндсэн зорилготой төсөл юм.

Хакатон уралдаан нь төслийн нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэх сургалтын хэрэгсэл болон ангилан ялгах цэгийн шинэлэг инновацийн шийдлийг агуулсан загвар дизайныг гаргаж ирэх зорилготой.

**ХОЁР. Ажлын зорилго**

Энэхүү ажлын зорилго нь “ХАКАТОН 2022-3R CONTHACKT UB” уралдаанд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах юм.

**ГУРАВ. Хэрэглэгдэхүүний жагсаалт**

| № | Бараа материал | Тоо хэмжээ | Тавигдах шаардлага                                                                                               |
|---|----------------|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Уртасгагч      | 15         | Гүйдэл:16А Хүчин чадал:3250Вт<br>Хүчдэл:220В Утасны урт:5м Хэт гүйдлийн хамгаалагч Универсал оролт:5 Унтраалга:5 |
| 2 | Маск           | 300        | Нэг удаагийн                                                                                                     |

|   |                                   |    |                                                                                                                             |
|---|-----------------------------------|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 3 | Гар ариутгагч                     | 10 | 500мл хэмжээтэй,<br>Найрлага: Ус, Глицерин,<br>Инзопропил спирт, Пропилен<br>гликоль, Салициллын хүчил,<br>Карбомер, Ментол |
| 4 | Бичгийн цаас                      | 6  | A4 210*297 мм, 80гр, боодол нь 500<br>ширхэгтэй цагаан өнгөтэй, double A<br>эсхүл түүнтэй дүйцэхүйц                         |
| 5 | Ватуум цаас                       | 30 | A3 хэмжээтэй                                                                                                                |
| 6 | Сертификат<br>хэвлэх фото<br>цаас | 50 | A4 хэмжээтэй, 150 гр                                                                                                        |

### **ДӨРӨВ. Хугацаа**

Материалын нийлүүлэлтийг 2022 оны 11 дугаар сарын 21-ны өдрөөс 2022 оны 11 сарын 24-ний өдрийн дотор хийнэ.

### **ТАВ. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага**

- Бичиг хэргийн бараа материал нийлүүлэх аж ахуйн нэгж байгууллага нь үйл ажиллагаа тогтмол явуулдаг байх;
- Өмнө энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай байх;
- Нийлүүлэх бараа материалыг цаг тухайд нь нийлүүлэх боломжит нөөц, үлдэгдэлтэй байх;
- Нийлүүлэх бараа материал нь чанарын шаардлага хангасан байх;

### **ЗУРГАА. Мэдээ, тайлан**

- Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаагаар ажил эхэлж, гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгч ажил гүйцэтгэсэн акт гүйцэтгэж өгснөөр ажил дуусгавар болно.
- Ажил гүйцэтгэгч ажлын явц, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнан ажиллах бөгөөд ажил гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн явц, үйл ажиллагаанд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн Судалгаа, мэдээлэл, сургалтын албаны дарга буюу 3R4UB төслийн менежер байнгын хяналт тавина.
- Ажил гүйцэтгэгч нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 3R4UB төслийн багийн холбогдох ажилтнуудтай байнгын холбоотой ажиллана.

### **ДОЛОО. Санал ирүүлэх материал**

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Үнийн санал
- Санал болгож буй барааны тодорхойлолт, барааны зураг
- Бараа нийлүүлэлтийн хуваарь

Саналаа дараах хаягаар ирүүлнэ:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан-9, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, 2 давхарт 208 тоот Утас: 70107644